



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦУУЛГА МАТЕРИАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
2025 оны 04-р сарын 29-ний өдрийн 10:00 цагт
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо,
Чингисийн өргөн чөлөө гудамж, “Номин юнайтед” төвийн
4.5 дугаар давхарт биечлэн болон цахим хосолсон
хэлбэрээр зохион байгуулагдана

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
2. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах.
3. ТУЗ-ийн гишүүдийг нөхөн болон улируулан сонгох.

ХУРЛЫН ДЭГ

1	Хурлын ирцийг бүртгэх (тооллогын комисс)	09:20 - 10:00
2	Хурлын ирцийг мэдээлэх (тооллогын комисс)	3 минут
3	Хурлын дарга хурлыг нээж үг хэлэх	2 минут
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан (Хурлын дарга, эсхүл гүйцэтгэх удирдлага)	15 минут
5	Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-н шийдвэрийг танилцуулах	3 минут
6	ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийн төслийг танилцуулах	5 минут
7	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	10 минут
8	Хувьцаа эзэмшигчдээс үг хэлэх, санал гаргах	30 минут
9	Хэлэлцсэн асуудлаарх санал хураалт	10 минут
10	Хурлын завсарлага	20 минут
11	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
12	Хурлын тогтоолыг танилцуулж, хурлыг хаах	5 минут

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар:

2024 онд “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Я.Наваан, И.Галбуян, А.Норсмаа, Х.Эрдэнэбаатар, Т.Сарантуяа, Т.Амартөр, нар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр М.Дамирансүрэн, Н.Энхчимэг, М.Ганцэцэг нар, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар М.Өлзийбат, компанийн Гүйцэтгэх захирлаар Х.Эрдэнэбаатар нар ажиллалаа.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хэтийн төлөв, зорилтыг тодорхойлон хууль, дүрэм, журамд заасан эрх үүргийнхээ хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, түүний дэргэдэх хороод нь хорооны эрх мэдлийн хүрээнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөл тайлант хугацаанд нийт 6 удаа биечлэн хуралдаж, 4 удаа эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж, гүйцэтгэх удирдлагын шийдвэрлүүлэхээр санал оруулсан асуудлуудыг цаг тухайд нь бүрэн шийдвэрлэж ажилласан.

Компанийн санхүүгийн нөхцөл байдлын талаар:

“Улсын Их Дэлгүүр” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу түрээслэгч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр түрээсийн төлбөрөө үе шаттай нэмэгдүүлж, сүүлийн 4 жилийн хугацаанд түрээсийн үнээ 53%-иар өсгөөд байна. 2024 онд нийт 11,038.8 сая төгрөгийн түрээсийн орлоготой, 3,361.4 сая төгрөгийн ашигтай ажилласан. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан хүмүүст холбогдох иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн Шүүхийн шийдвэрийн дагуу “Номин Реалтор” ХХК-иас төлөгдсөн 2,400.0 сая төгрөгийн орлого дээрх ашгийн дүнд орсон болно.

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны зардал 7,699.0 сая төгрөг байна. Үйл ажиллагааны зардлын 2.0 хувийг хөдөлмөрийн зардал, 45.7 хувийг ашиглалтын зардал, 0.1 хувийг барилгын урсгал засварын зардал, 17.6 хувийг хөрөнгийн элэгдлийн зардал, 27.4 хувийг зээлийн хүүгийн зардал, 2.6 хувийг үл хөдлөх хөрөнгийн болон газрын татвар, 2.4 хувийг даатгалын зардал, 2.2 хувийг бусад зардал эзэлж байна. Үйл ажиллагааны бус орлогын хувьд банкны харилцах дансанд тооцсон хүүгийн орлого 3.1 сая төгрөг байна.

2024 онд нийт хөрөнгийн дүн 14,087.0 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 1.0 хувь буюу 158.7 сая төгрөг байна. Эргэлтийн хөрөнгийн 30.0 хувийг банкны харилцах дансны үлдэгдэл, 11 хувийг татварын авлага, 19 хувийг хангамжийн материал, 40 хувийг урьдчилж төлсөн зардал буюу даатгалын зардал эзэлж бна.

Нийт хөрөнгийн дүнд эргэлтийн бус хөрөнгө 99 хувь буюу 13,928.3 сая төгрөгийг эзэлж байгаагийн 73.2% буюу 10,201.2 сая төгрөгийг барилга байгууламж, 22.3% буюу 3,115.3 сая төгрөгийг машин тоног төхөөрөмж, 0.5 сая төгрөгийг тавилга эд хогшил, үлдэх 4.5% буюу 611.3 сая төгрөгийг хөрөнгө оруулалт болон хойшлогдсон татварын хөрөнгө эзэлж байна.

Оны эхэнд дансны авлага 16.9 сая төгрөг, оны эцэст 17.4 сая төгрөг байна. Авлагыг ангилж үзвэл НӨАТатварын авлага 3.1 сая төгрөг, орлогын албан татварын авлага 14.2 сая төгрөг, бусад авлага 0.1 сая төгрөг байна.

Оны эхэнд 592.2 сая төгрөгийн богино хугацаат өглөгтэй байснаас оны эцэст 1,146.4 сая төгрөг болсон.

2024 онд “Улсын Их Дэлгүүр” ХК нь Шүүхийн шийдвэрийн дагуу хөндлөнгийн Аудитын зөвлөмжид үндэслэн 5 этгээдэд төлөх ёстой галын хохирлын 5,063.7 сая төгрөгийн өглөгийг дансанд бүртгэж, нийт 4,263.7 сая төгрөгийн төлбөрийг төлж барагдуулан оны эцэст энэ тооцооноос 1 этгээдэд хамаарах 800.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Үлдэх 346.4 сая төгрөгөөс 189.0 сая төгрөг нь зээлийн хүүгийн өглөг, 60.7 сая төгрөг нь холбоотой талын өглөг, 28.9 сая төгрөг нь цалин, НДШ, татварын өглөг, 67.9 сая төгрөг нь дотоодын харилцагчид төлөх ёстой /УСУГ, ДШСГ, барьцаа/ өглөг байна.

Компанийн үйл ажиллагааны талаар:

Компани нь татвараа үнэн зөв тодорхойлох, төлөх, тайлагнах үүргээ бүрэн биелүүлж, 2024 онд НӨАТатварт 628.2 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 184.4 сая төгрөг, ХХОАТатварт 13.3 сая төгрөг, НДШимтгэлд 18.6 сая төгрөг, газрын татварт 13.9 сая төгрөг, нийт дүнгээр 858.4 сая төгрөгийг Монгол улсын төсөвт төвлөрүүлсэн.

2024 онд Улсын Их Дэлгүүрийн барилгын 1-р давхрын гадна талын хатаасан бор шил, 2 – 6-р давхрын цонхны хагарсан шил солих, 6-р давхрын шалны хулдаас наах, 3-р давхрын зүүн жигүүрт агааржуулалтын хоолойд 9 ширхэг гар хавхлаг суурилуулах, 2-р давхрын агаар сорох хэсгийн шинэ холболтыг хийх, 3 болон 5 дугаар давхрын урд хэсэгт систем кондейшн суурилуулах, 7-р давхарт хиншүү сорох шугамын төгсгөлийг гадагш гаргах, урд авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээг будаж шинэчлэх зэрэг барилгын чанар байдлыг хадгалах, орчин нөхцлийг сайжруулахтай холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын байгууллагын зөвлөмжийн талаар:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар сонгогдсон хөндлөнгийн аудитын байгууллага болох “Сүлд-Аудит” ХХК-ийн зүгээс “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэл нь Монгол Улсын Сангийн Яамнаас баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт”, “Дансны үлгэрчилсэн заавар”-ын дагуу аккруэл сууриар бэлтгэгдсэн ба энэхүү тайлагналын суурь нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцэж байна гэсэн дүгнэлт өгсөн.



СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2025.03.10 № 25/11
танай -ны №

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Өөрчлөлтгүй дүгнэлт

Бид “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар, журмын дагуу бүх материаллаг зүйлсийг хамруулан үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал, /МНБ/



Ч.ГҮНДБАЯР

Санхүүгийн тайлан

Сүлд-Аудит ХХК

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2023	12/31/2024
А.ХӨРӨНГӨ			
1.Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1	234,811.20	47,671,547.23
Дансны авлага	2	-	390,000.00
Татвар, НДШ-ийн авлага	2	704,282,423.28	17,386,424.31
Бусад авлага	2	-	-
Бараа материал	3	132,244,595.48	29,441,628.47
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	4	9,464,568.52	63,846,903.22
Эргэлтийн хөрөнгийн дүн		846,226,398.48	158,736,503.23
2.Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	5	14,315,710,599.92	13,317,022,054.90
Биет бус хөрөнгө		-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6	33,811,920.00	33,811,920.00
Хойшлогдсон татварын хөрөнгө	7	-	18,897,260.27
Бусад эргэлтийн бус хөрөнгө	8	-	558,560,700.64
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		14,349,522,519.92	13,928,291,935.81
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		15,195,748,918.40	14,087,028,439.04
Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
1.Өр төлбөр			
Дансны өглөг	9	256,067,835.10	928,554,331.13
Цалингийн өглөг	10	3,656,126.23	6,671,477.19
Татварын өр	10	51,435,912.63	5,595,409.32
НДШ-ийн өглөг	10	14,152.42	220,396.62
Хүүний өглөг	11	114,657,534.25	188,972,602.75
Ногдол ашгийн өглөг	11	15,433,581.00	15,433,581.00
Урьдчилж орсон орлого	12	150,000,000.00	-
Бусад богино хугацаат өр төлбөр	11	960,674.13	946,675.63
Богино хугацаат өр төлбөрийн дүн		592,225,815.76	1,146,394,473.64
Урт хугацаат зээл	10	17,000,000,000.00	17,000,000,000.00
Хойшлогдсон татварын өр		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		17,000,000,000.00	17,000,000,000.00
Өр төлбөрийн нийт дүн		17,592,202,852.42	18,146,394,473.64
2.Эздийн өмч			
а.Төрийн			
б.Хувийн			
в. Хувьцаат	13	3,680,785,000.00	3,680,785,000.00
Халаасны хувьцаа	13	(175,964,106.00)	(175,964,106.00)
Нэмж төлөгдсөн капитал	13	133,351,798.00	133,351,798.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14	1,600,084,101.82	1,600,084,101.82
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	15	(7,634,733,691.18)	(9,297,622,828.42)
Эздийн өмчийн дүн		(2,396,476,897.36)	(4,059,366,034.60)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		15,195,748,918.40	14,087,028,439.04

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно




Санхүүгийн тайлан

Сүлд-Аудит ХХК

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2023	12/31/2024
Борлуулалтын орлого (цэвэр)	16	8,310,638,334.26	11,038,785,569.00
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг /алдагдал/		8,310,638,334.26	11,038,785,569.00
Түрээсийн орлого		-	-
Хүүгийн орлого	17	-	2,880,143.35
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	17	-	300,001.00
Борлуулалт, маркетингийн зардал	18	4,554,860.04	5,364,870.20
Ерөнхий ба удирдлагын зардал	18	5,469,870,812.08	5,582,092,641.64
Санхүүгийн зардал	19	1,679,958,904.13	2,111,575,342.47
Бусад зардал	18	17,775,586.58	99,208.82
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)	20	(1,031,900,885.00)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		106,577,286.43	3,342,833,650.22
Орлогын татварын зардал	21	-	(18,609,245.93)
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)		106,577,286.43	3,361,442,896.15
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		106,577,286.43	3,361,442,896.15
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-
Бусад олз (гарз)		-	-
Орлогын нийт дүн		106,577,286.43	3,361,442,896.15
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		-	-

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



Санхүүгийн тайлан

Сүлд-Аудит ХХК

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

							/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн	
2023 оны 12-р сарын 31-ний өдөр	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(7,634,733,691.18)	(2,396,476,897.36)	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-	-	
Залруулсан үлдэгдэл	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(7,634,733,691.18)	(2,396,476,897.36)	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(5,024,332,033.39)	(5,024,332,033.39)	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					3,361,442,896.15	3,361,442,896.15	
Өмчид гарсан өөрчлөлт							
Зарласан ногдол ашиг							
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							
2024 оны 12-р сарын 31-ний өдөр	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(9,297,622,828.42)	(4,059,366,034.60)	

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.




Санхүүгийн тайлан

Сүлд-Аудит ХХК

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2023	12/31/2024
/төгрөгөөр/		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	10,889,542,745.20	31,661,700,823.58
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	10,266,760,800.00	12,459,425,880.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Бусад мөнгөн орлого	622,781,945.20	19,202,274,943.58
Мөнгөн зарлагын дүн (-)	10,644,494,556.64	31,398,021,118.14
Ажиллагчдад төлсөн	97,659,489.23	130,361,032.35
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	22,792,520.00	18,549,573.94
Ашиглалтын зардалд төлсөн	3,788,303,438.54	3,814,287,040.03
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	4,421,099,900.24	108,303,574.62
Хүүний төлбөрт төлсөн	1,679,958,904.13	2,037,260,273.97
Татварын байгууллагад төлсөн	434,918,535.50	839,544,209.23
Даатгалын төлбөрт төлсөн	186,000,000.00	186,000,000.00
Бусад мөнгөн зарлага	13,761,769.00	24,263,715,414.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	245,048,188.56	263,679,705.44
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	249,933,511.50	219,123,112.76
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	249,933,511.50	219,123,112.76
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(249,933,511.50)	(219,123,112.76)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	10,002,880,143.35
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	10,000,000,000.00
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	2,880,143.35
Мөнгөн зарлагын дүн (-)	-	10,000,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	10,000,000,000.00
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	2,880,143.35
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,885,322.94)	47,436,736.03
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	<i>5,120,134.14</i>	<i>234,811.20</i>
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	<i>234,811.20</i>	<i>47,671,547.23</i>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



 УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

2025 оны 03 дугаар
сарын 20 -ны өдөр

№: 25/06

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг,
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хурлын
шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг энэхүү тогтоолын
хавсралтаар дүгнэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар
хэлэлцүүлэн батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

"Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны өдрийн
25/06 дугаартай тогтоолын Хавсралт



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- 1.1. ОРЛОГО: Компани 2024 онд түрээсийн үйл ажиллагаанаас 8,638,785,569.00 төгрөгийн орлоготой ажилласан.
- 1.2. ЗАРДАЛ: Компани 2024 онд үндсэн үйл ажиллагаандаа 7,699,032,854.31 төгрөгийн зардалтай ажилласан.
- 1.3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ: Компани дээрх орлого болон зардалд үндэслэн 2024 онд үндсэн үйл ажиллагаанаасаа 939,752,714.69 төгрөгийн ашиг олсон байна.

2. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- 2.1. БУСАД ОРЛОГО: Компани 2024 онд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01-р сарын 13-ны өдрийн 001/ХТ2023/00147 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 21-ний өдрийн 210/МА2023/00845 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2023 оны 07-р сарын 04-ний өдрийн шүүх хуралдааны 001/ХТ2023/00147 дугаартай тогтоолын дагуу хариуцагч нараас 2,400,000,000 төгрөгийн орлого хүлээн авсан.
- 2.2. БУСАД ЗАРДАЛ: Компани 2024 онд Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11-р сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийдвэр, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 06-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2023 оны 07-р сарын 06-ны өдрийн хуралдааны 517 дугаартай тогтоолын дагуу бусдад 4,263,715,414.00 төгрөгийн хохирлын төлбөр төлсөн.
- 2.2. БУСАД АШИГ, АЛДАГДАЛ: Компани 2024 онд үндсэн бус үйл ажиллагааны 3,080,935.53 төгрөгийн ашигтай, хойшлогдсон татварын тооцоо 18,609,245.93 төгрөг, нийт 3,361,442,696.15 төгрөгийн ашигтай ажилласан байна.

3. ЦЭВЭР АШИГ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ: "Улсын их дэлгүүр" ХК нь 2024 онд 3,420,191.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба бодит гүйцэтгэлээр 3,361,442.9 сая төгрөгийн ашигтай ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 98.3% байна.

4. ДҮГНЭЛТ: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн биелэлтийг хангалттай гэж дүгнэв.

НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

 УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

2025 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

№: 25/03

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 47 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани тайлант жилийн болон өмнөх онуудад бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй, мөн Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 517 дугаартай тогтоолын дагуу Улсын их дэлгүүрийн барилгад гарсан гал түймэртэй холбогдуулан бусдад учирсан хохирлыг нөхөн төлсөн зэргээс үүдэн Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан “ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх”, “ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх” шаардлагуудыг хангаж чадахгүй байх тул 2024 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан танилцуулахаар тогтоосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ
БОЛОМЖГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХДАА ҮНДЭСЛЭЛ БОЛГОСОН
ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ

47.1. Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

47.1.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

47.1.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 30.5-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Төрөл	Төсөв /Мян.төг/
1	ТУЗөвлөлийн ердийн гишүүний цалин урамшуулал	24,000,000
2	ТУЗөвлөлийн хараат бус гишүүний цалин урамшуулал	18,000,000
3	ТУЗөвлөлийн хурал зохион байгуулах төсөв	800,000
4	Нийт төсөв	42,800,000

*Жич: Энэхүү төсөв нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хоорондын
Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсөв болно*

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ НӨХӨН БОЛОН УЛИРУУЛАН СОНГОХ АСУУДАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн И.Галбуян, Т.Амартөр нар үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос дээрх 2 чөлөөлөгдсөн гишүүний оронд гарсан сул орон тоонд ТУЗ-ийн ердийн гишүүнд шинээр нөхөн сонгуулахаар 2 нэр дэвшигчийг санал болгосон.

Харин компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй байгаа ТУЗ-ийн ердийн гишүүн Я.Наваан, А.Норсмаа, Х.Эрдэнэбаатар, Т.Сарантуяа, ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Дамирансүрэн, Н.Энхчимэг, М.Ганцэцэг нарыг улируулан сонгуулахаар санал оруулсан.

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу Хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох ёстой учир шинээр нөхөн сонгогдох 2 нэр дэвшигчээс гадна бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй байгаа ТУЗ-ийн 7 гишүүнийг ч мөн адил хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан улируулан сонгох шаардлагатай болсон.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүнд нэр дэвшигчид

1. Янсанжавын Наваан (Улируулан сонгох)

- ✧ 1984 онд Улаанбаатар хотод төрсөн
- ✧ Нийслэлийн 1-р дунд сургууль
- ✧ 2002-2006 онд МУИС-ийн, Эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн.
- ✧ ИБУИНВУ-ийн University of Wales сургуульп бизнесийн удирлагын чиглэлээр магистрийн зэрэг хамгаасан.
- ✧ 2005-2008 онд “Номин Трейдинг” ХХК-д маркетингийн менежер
- ✧ 2008-2013 онд “Номин Холдинг” ХХК-ийн Борлуулалт маркетингийн газрын захирал
- ✧ 2014-2016 онд “Номин Трейдинг” ХХК-ийн Номин электроникс салбарын захирал
- ✧ 2016-2020 онд “Номин Холдинг” ХХК-ийн Стратеги төлөвлөлт, судалгааны газрын захирал
- ✧ 2020 оноос одоог хүртэл “Номин холдинг” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
- ✧ 2021 оноос “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.

2. Алтангэрэлийн Норсмаа (Улируулан сонгох)

- ✧ 1971-1981 онд Төв аймгийн 1-р 10-н жилийн сургууль,
- ✧ 1981-1985 онд МУИС-ийн Эдийн засгийн факультетыг Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн.
- ✧ 1985-2004 оны 3-р сар хүртэл “АПУ” ХК-д нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчоор
- ✧ 2004-2006 онд “Фаст-Мани” Хадгаламж зээлийн хоршоог үүсгэн байгуулж ерөнхий нягтлан бодогчоор
- ✧ 2006 оны 3-р сараас “Номин Холдинг” ХХК-ийн Дотоод аудитын газарт ахлах дотоод аудитор, газрын дарга, Дотоод хяналт, эрсдэлийн үнэлгээний газрын захирлаар
- ✧ 2011 оноос “Эрдэнэт Хивс” ХХК-ийн Хяналтын зөвлөлийн даргаар
- ✧ 2010 оноос “Хөвсгөл Усан зам” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүнээр
- ✧ 2010 оноос “Номин Юнион” ХЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга
- ✧ 2016-2021 оны 03 сар хүртэл “Номин Холдинг” ХХК-ийн СНББГ-ын захирлаар
- ✧ 2021 оны 03 сараас “Номин юнион” ХЗХ-ны Гүйцэтгэх захирлаар
- ✧ 2021 оноос “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.

3. Хүрэлхүүгийн Эрдэнэбаатар (Улируулан сонгох)

- ✧ 1989 онд Архангай аймагт төрсөн
- ✧ 1995-2005 онд Архангай аймгийн Хүмүүн II дунд сургууль,
- ✧ 2005-2009 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Бизнесийн эдийн засагч мэргэжлээр Бакалавр зэрэгтэй төгссөн.
- ✧ 2011-2014 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Эдийн засагч мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн.
- ✧ 2009 онд “Монхангай групп”-т Эдийн засагч, агуулахын менежер,
- ✧ 2010 онд Хас банканд Зээлийн эдийн засагчаар,
- ✧ 2013-2015 онд Бодь групп, “Улаанбаатар такси транспорт сервис” ХХК-д Санхүүгийн менежер
- ✧ 2015 оноос одоог хүртэл “Номин холдинг” ХХК-д Хэлтсийн захирлаар ажиллаж байна
- ✧ 2021 оноос “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна
- ✧ 2023 оны 09-р сараас “Улсын их дэлгүүр” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

4. Тэрбишийн Сарантуяа (Улируулан сонгох)

- ✧ 1980 онд Хэнтий аймагт төрсөн
- ✧ 1999-2003 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль төгссөн.
- ✧ “Номин тав трейд” ХХК-д салбарын эрхлэгчээр 10 жил
- ✧ “Номин тав трейд” ХХК-д Ахлах менежерээр 2 жил
- ✧ 2021 оны 01 сараас одоог хүртэл “Номин тав трейд” ХХК-ийн дэлгүүрийн сүлжээ хариуцсан захирлаар ажиллаж байна.
- ✧ 2021 оноос “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.

5. Сэнгэдоржийн Хосбаяр (Сул орон тоонд шинээр нөхөн сонгох)

- ✧ 1975 оны 6-р сарын 21-ний өдөр Ховд аймагт төрсөн.
- ✧ 1982-1992 онд Ховд аймгийн арван жилийн дунд сургууль төгссөн.
- ✧ 1992-1996 онд МУИС-ийг Шинжээч няглан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн.
- ✧ 1995-1996 онд “Бүргэд” ХХК-д Тооцооны нягтлан бодогчоор
- ✧ 1996-1999 онд “Разноимпэкс Нэгтгэл” ХК-д Тооцооны нягтлан бодогч, орлогч нягтлан бодогч,
- ✧ 1996-2002 онд “Номин Холдинг” ХХК-д Ахлах нягтлан бодогчоор,
- ✧ 2003-2012 онд “Номин Холдинг” ХХК-ийн Санхүү, ня-бо бүртгэлийн газрын даргаар,
- ✧ 2013-2014 онд “Номин Холдинг” ХХК-ийн БХГ-ын захирал
- ✧ 2014-2015 онд “Номин Холдинг” ХХК-ийн Санхүүгийн бизнес хариуцсан захирлаар,
- ✧ 2015-2024 онд “Номин Холдинг” ХХК-ийн Санхүүгийн удирдлагын газрын захирлаар,
- ✧ 2024 оноос одоог хүртэл “Номин холдинг” ХХК-ийн Санхүүгийн бизнес хариуцсан захирлаар ажиллаж байна.

6. Жаргалын Дөлгөөн (Сул орон тоонд шинээр нөхөн сонгох)

- ✧ 1995 онд төрсөн. Эмэгтэй
- ✧ 2002-2012 онд Монгол-Германы хамтарсан Нийслэлийн 38-р дунд сургуулийг төгссөн.
- ✧ 2012-2014 онд ХБНГУ-ын Heidelberg-ийн их сургууль төгссөн.
- ✧ 2014-2019 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн.
- ✧ 2024-2025 онд СЭЗИС-д магистрын зэрэг хамгаалсан.
- ✧ 2022 оноос одоог хүртэл “Сэтгэлийн хүүрнэл” ТББ-ын удирдах зөвлөлийн даргаар,
- ✧ 2020-2024 онд “Номин холдинг” ХХК-ийн Эрх зүйн газарт Гадаад гэрээний хуульчаар,
- ✧ 2021-2024 онд “Өргөжих реалтор” ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар,
- ✧ 2022-2024 онд “Номин пикчерс” ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар,
- ✧ 2023-2024 онд “Омни тех” ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар,
- ✧ 2024 оны 10-р сараас одоог хүртэл “Номин холдинг” ХХК-ийн Хуулийн хэлтсийн даргаар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчид

1. Мөнхнасангийн Дамирансүрэн (Улируулан сонгох)

- ✧ 1964 онд Багшийн сургуулийн багш мэргэжлээр.
- ✧ 1979 онд УИС-ийг Хуульч мэргэжлээр төгссөн.
- ✧ 1979-1985 онд Батлан хамгаалах яаманд Хуулийн зөвлөхөөр
- ✧ 1985-2021 онд Монгол Улсын Дээд шүүхэд шүүгч, зөвлөхөөр ажилласан.
- ✧ 2023 оны 08-р сараас “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

2. Нанзаддоржийн Энхчимэг (Улируулан сонгох)

- ✧ 2000 онд “Түшээ” дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн
- ✧ 2001 онд МУИС-ийг Түүхч мэргэжлээр төгссөн
- ✧ Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч
- ✧ 2003 оноос хойш Өмгөөлөгчөөр ажиллаж байгаа
- ✧ 2015 оноос хойш “Гранд партнерс” ХХН-ийн захирал
- ✧ 2023 оны 08-р сараас “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

3. Мэндсоогийн Ганцэцэг (Улируулан сонгох)

- ✧ 2000 онд “Түшээ” дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн.
- ✧ 2005 онд “Цагдаагийн академи”-д хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан
- ✧ Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч
- ✧ 2000-2004 онд “Сувд” хууль зүйн товчоонд хуульч
- ✧ 2004-2005 онд Авто тээврийн газарт бүртгэлийн ажилтан
- ✧ 2005-2006 онд “Хасагт хайрхан” ХЗС-д багш
- ✧ 2006-2008 онд Иргэний нисэхийн ерөнхий газарт Мэдээллийн ажилтан
- ✧ 2008-2012 онд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Далайн захиргаанд Хуулийн зөвлөх
- ✧ 2012-2013 онд Зам тээврийн яаманд Мэргэжилтэн
- ✧ 2008 оноос өмгөөлөгчөөр
- ✧ 2023 оны 08-р сараас “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны өдрийн
25/05 тоот тогтоолоор батлав

**“Улсын их дэлгүүр” ХК-ийн 2025.04.29-ний өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загвар**

- ✧ Хурал хуралдах газар /хаяг, байршил/: Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө хаягт байрлах “Номин юнайтед” төвийн 4.5 дугаар давхрын “Улаанбаатар” хурлын танхимд биечлэн болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.
 - ✧ Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:
 - ✧ Хувьцааны тоо :..... Регистр №
 - ✧ Хурлаар шийдвэрлэх асуудлууд:
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах.

а. Зөвшөөрсөн
б. Татгалзсан
в. Түдгэлзсэн
 - Компанийн ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах.

а. Зөвшөөрсөн
б. Татгалзсан
в. Түдгэлзсэн
 - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив аргаар сонгох.

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид			Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
Сонгогдох ТУЗ-ийн гишүүний тоо				9
Эзэмшиж буй хувьцааны тоо				
Нийт саналын эрхийн тоо				
1	Ердийн гишүүн	Я.Наваан	Улируулан сонгох	
2		А.Норсмаа	Улируулан сонгох	
3		Х.Эрдэнэбаатар	Улируулан сонгох	
4		Т.Сарантуяа	Улируулан сонгох	
5		С.Хосбаяр	Шинээр нөхөн сонгох	
6		Ж.Дөлгөөн	Шинээр нөхөн сонгох	
1	Хараат бус гишүүн	М.Дамирансүрэн	Улируулан сонгох	
2		М.Ганцэцэг	Улируулан сонгох	
3		Н.Энхчимэг	Улируулан сонгох	

Санамж:

- Санал өгөгч нь өгөх саналынхаа өмнөх үсгийг дугуйлна.
- Саналын хуудсыг балласан, засварласан бол хүчингүйд тооцно.
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Кумулятив аргаар таны санал өгөх эрхийн нийт тоо нь таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор буюу 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл $900 \text{ саналын эрхтэй} / 100 \times 9 \text{ гишүүн} = 900$ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

2025/ / /

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Тооллогын комиссын дарга: _____
 Гишүүд: _____

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ
ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД**

(ТОГТООЛЫН ТӨСӨЛ - 1)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 29-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай (батлахаас татгалзсугай).

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

(ТОГТООЛЫН ТӨСӨЛ - 2)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 29-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай (батлахаас татгалзсугай).
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоолын хавсралтаар батлагдсан цалин хөлсийг зохих журмын дагуу олгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлыг энэхүү тогтоолын хавсралтад заасан төсөвт багтаан гаргах, зардлын зарцуулалтыг компанийн санхүүгийн тайлан тэнцэлд зохих журмын дагуу бүртгэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал болон Ахлах нягтлан бодогч нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

(ТОГТООЛЫН ТӨСӨЛ - 3)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 29-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, компанийн дүрмийн 7.3.4 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
 - 1.1.-НЫ
 - 1.2.-НЫ
 - 1.3.-НЫ
 - 1.4.-НЫ
 - 1.5.-НЫ
 - 1.6.-НЫ
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
 - 2.1.-НЫ
 - 2.2.-НЫ
 - 2.3.-НЫ
3. Холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны дүрэм, журам зэрэг компанийн засаглалын тогтолцооны эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
4. Шинээр томилогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг холбогдох эрх зүйн актад тусгасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид тус тус мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Өлзийбат/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ОРОЛЦОХ ЗААВАРЧИЛГАА

Цахим хуралд бүртгүүлэх:

- ❖ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг **Zoom meeting** программ дээр зохион байгуулна.
- ❖ Хуралд оролцох саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 89885120 дугаарын утсаар холбогдож, өөрийн и-мэйл хаягийг бүртгүүлэх ба цахим хуралд оролцох холбоос буюу линкийг тухайн хувьцаа эзэмшигчийн бүртгүүлсэн и-мэйл хаягруу илгээнэ.
- ❖ Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч нь цахим хуралд оролцох линк хүлээн авахын өмнө өөрийн цахим иргэний үнэмлэх, эсхүл e-mongolia-иас татаж авсан лавлагааг ТУЗ-ийн нарийн бичгийн даргын uid.secretary@gmail.com хаягруу явуулсан байх шаардлагатай.

Цахим хуралд нэвтрэх, хуралд оролцох:

- ❖ Тооллогын комисс цахим хурлын программд нэвтрэх хүсэлт илгээсэн хэрэглэгчийг хуралд оролцох саналын эрхтэй